

АВЛИГЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН 2015 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2015.12.29

| № | Төлөвлөсөн ажил   | Хариуцан хэрэгжүүлэх ажилтан | Хугацаа  | Шаардлагатай төсөв /төгрөг/ | Биелэлт /хагас жилээр/  |
|---|---|------------------------------|----------|-----------------------------|---|
| 1 | Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтанг ажиллах нөхцөл болоцоогоор хангах   | Д.Нацагдорж                  | Жилдээ   | 1,910,244                   | УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05-р тогтоолоор баталсан Албан тушаалтны ХАС-ын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 3.1-ийн дагуу НДАА-ны даргын 2014.05.15-ны 26 дугаар тушаалаар Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах шинжээч Я.Сарансүхийг эрх бүхий албан тушаалтнаар томилж, ажлын байрны тодорхойлолтод нь энэ тухай оруулсан бөгөөд албан тушаалынх нь цалингийн 20%-тай тэнцэх хэмжээний нэмэгдэл урамшуулал тооцон олгож байна. 2015 оны байдлаар ЭБАТ-д 1,627,359.8 төгрөгийн нэмэгдэл олгосон.                              |
| 2 | Албан хаагчдын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдлийг хуулийн дагуу хугацаанд нь гаргаж, цахим системд бүртгэх | Я.Сарансүх                   | Жилдээ   | Шаардлагагүй                | АТГ-ын даргын тушаалаар батлагдсан ХАС-ын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны шинэчилсэн жагсаалтын дагуу давхардсан тоогоор холбогдох 13 албан хаагчийн мэдүүлгийг авч, тайлан мэдээг зохих хугацаанд гаргаж өгсөн. Мөн шинээр албан тушаалд томилогдож буй 11 иргэний ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг авч АТГ-аар хянуулсан. Аудитор, шинжээчдийг шинэ аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авч байгаа бөгөөд оны эхний байдлаар давхардсан тоогоор 98 мэдүүлгийг АТГ-ын програмд бүртгэсэн. |
| 3 | Мэдүүлэг гаргагч нарт мэдүүлгийн бүрдүүлэлтийн талаар зөвлөгөө өгөх, гарын авлага материал тараах   | Я.Сарансүх                   | 1-р сард | Шаардлагагүй                | ХАС-ын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл гаргагч нарыг гарын авлагаар хангаж, шаардлагатай тухай бүр зөвлөгөө өгч ажилласан.   |
| 4 | Шаардлагатай мэдээ, тайланг зохих хугацаанд нь гаргаж эрх бүхий байгууллагат хүргүүлэх  | Я.Сарансүх                   | Жилдээ   | Шаардлагагүй                | ХАС-ын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, мэдэгдэл гаргагч нарын мэдүүлэг, мэдэгдлийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж тайлагнасан.   |
| 5 | Шинээр ажилд орсон албан хаагчдаар нууцын баталгаа гаргуулах  | Я.Сарансүх                   | Жилдээ   | Шаардлагагүй                | 2015 оны байдлаар шинээр ажилд томилогдсон 12 албан хаагчаар нууцын баталгаа гаргуулж авсан.  |

|   |   |             |              |              |   |
|---|---|-------------|--------------|--------------|---|
| 6 | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутам мэдээлэх                                   | Я.Сарансүх  | 6, 12-р сард | Шаардлагагүй | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр НЗДТГ-ын НЗУХ-т тайлагнаж ажилласан.   |
| 7 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг ажилтан, албан хаагчдад сурталчлах  | Я.Сарансүх  | Жилдээ       | Шаардлагагүй | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай тогтоомжийг зурагт хуудас болон олон нийтийн цахим сүлжээгээр албан хаагчдад сурталчилсан. 2015.10.22-нд Азийн хөгжлийн банкнаас зохион байгуулсан авлигын эсрэг семинарт ЗХХ-н дарга Я.Сарансүх оролцож гэрчилгээ авсан.   |
| 8 | Ажилтан, албан хаагчдад давхар ажил эрхлэлттэй холбоотой зөвшөөрөл олгох, хязгаарлалтыг хэрэгжүүлэх                 | Д.Нацагдорж | Жилдээ       | Шаардлагагүй | Ажилтан, албан хаагчдад давхар ажил эрхлэлт, албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон хориглолт, хязгаарлалтын талаар зөвлөгөө, санамжийг видео кино хэлбэрээр өгсөн. 2015 оны байдлаар давхар ажил эрхлэлттэй холбоотой зөвшөөрөл олгосон, хязгаарлалтыг хэрэгжүүлсэн тохиолдолд гараагүй байна.  |
| 9 | Байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, ажилтан, албан хаагчдад холбогдох ёс зүйн дүрмийг мөрдүүлэх | Я.Сарансүх  | 8-р сард     | Шаардлагагүй | Байгууллагын дэргэдэх ёс зүйн хороог шинэчлэн байгуулах нууц санал хураалт явуулснаар ёс зүйн хорооны даргаар ЧХХ-ийн дарга С.Буманцэцэг, гишүүдээр ЗХХ-ийн дарга Я.Сарансүх, ГАХ-ийн шинжээч Н.Нарангэрэл нарыг томиллоо. Ёс зүйн хороо 2015 оны байдлаар 2 удаа хуралдан, 2015 оны ажлын төлөвлөгөөг баталж, тайланг хэлэлцсэн. Төлөвлөгөөний дагуу сургалт, суртадчилгааны ажлыг хийснээр албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажилласнаар ёс зүйн зөрчлийн талаар гомдол гараагүй. |

|    |  |                               |        |              |  |
|----|--|-------------------------------|--------|--------------|--|
| 10 | Мэдээллийн ил тод байдлыг хангаж, Шилэн дансы тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах | Б.Сэргэлэн,<br>С.Болор-Эрдэнэ | Жилдээ | Шаардлагагүй | <p>Холбогдох хууль, журмын дагуу байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэс үүсгэж, шилэн дансны нэгдсэн системд 2015 оны төсөв, 2015 оны 1-11 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, 1-3 дугаар улирлын санхүүгийн тайлан, болон бусад холбогдох мэдээллийг нийтлэсэн. Нийт мэдээний тоо 15. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор: Байгууллагын стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, 2014 оны үйл ажиллагааны тайлан, тогтоол, шийдвэрийн 2014, 2015 оны гүйцэтгэлийн мэдээ, 2014, 2015 оны авилгын эсрэг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээллийн ил, тод байдал, иргэдийн мэдээлэл хүлээн авах эрхийг хангаж ажиллах 2014 оны төлөвлөгөөний тайлан, 2015 оны эхний хагас жилийн KPI, 2015 оны сургалтын төлөвлөгөө, Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэхэд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, тайлан, цаг үеийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд нийтлэсэн. Нийт мэдээний тоо 45</p> <p>Хүний нөөцийн бодлогын ил тод байдлыг хангах зорилгоор: Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтны ёс зүйн дүрэм, ажлын байрны тодорхойлолт, мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудсанд нийтлэсэн.</p> |
|----|--|-------------------------------|--------|--------------|--|

|    |   |             |                      |              |   |
|----|---|-------------|----------------------|--------------|---|
| 11 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод аудитын хяналтын тогтолцоог сайжруулах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, дахин гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах | Д.Нацагдорж | Жилдээ               | Шаардлагагүй | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад сар бүр хийсэн шилэн дансны хяналтын мэдээллийг нийслэл, дүүргээр нь нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Нийслэлийн Дотоод аудитын хорооны хуралд 2015 оны 06 дугаар сарын 08-ны өдөр тус тус танилцуулсан. Тус хурлын тэмдэглэлийг үндэслэн НЗД-ийн захирамжаар мэдээллээ оруулаагүй 2 байгууллагын захиралд сануулах сахилгын арга хэмжээ авсан. Мөн 2015 оны эхний хагас жилийн үзлэгийн дүнг нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 8 дугаар сарын 27-ны өдрийн хуралд танилцуулан тус хурлын тэмдэглэлийг үндэслэн НЗД-ын захирамжаар 18 байгууллагын удирдлагад сануулах сахилгын арга хэмжээ авсан. |
| 12 | Тухайн жилд явуулах хяналт шалгалтын төлөвлөгөөг гаргаж батлуулах   | Д.Нацагдорж | 2,3,4 дүгээр улиралд | Шаардлагагүй | Нийслэлийн Дотоод аудитын хорооны 2015.01.21-ний өдрийн хурлаар байгууллагын 2014 оны аудитын тайланг хэлэлцүүлж, 2015 оны аудитын төлөвлөгөөг батлуулсан.  |
|    | БҮГД  |             |                      | 1,298,000    |   |

Тайлан  
гаргасан:

Захиргаа, хуулийн хэлтсийн дарга

Я.Сарансүх